

КИНОНД НАСНЫ АНГИЛАЛ ТОГТООХ ШАЛГУУР, ТҮГЭЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ БАТЛАГДЛАА

Киноны насны ангиллын нэгдсэн тогтолцоо Монгол улсад хэрэгжиж эхэллээ.

Монгол Улсад киног үзэгчдийн насанд тохируулан ангилах, бүх төрлийн сувгаар түгээхэд баримтлах нэгдсэн шалгуур, шаардлага бий боллоо.

Кино урлагийн зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран 2026 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 22/100 дугаар хамтарсан тогтоолоор “Кинонд насны ангилал тогтоох шалгуур, түгээхэд баримтлах журам”-ыг батлан гаргасан. Тус журам нь Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдэж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэллээ.

Энэхүү журмаар Монгол Улсад кино бүтээлд насны ангилал тогтоох, тэмдэг тэмдэглэгээг хэрэглэх, тухайн насны ангилалд нийцүүлэн киног түгээх, хэрэгжилтэд хяналт тавих нэгдсэн зохицуулалтын орчин бүрдэж байна.

Журам хэнд үйлчлэх вэ?

Журмыг Монгол Улсын нутаг дэвсгэрт кино бүтээх, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээд, киноны эрх эзэмшигч, кино зуучлагч, тухайлбал кино театр, телевиз, ОТТ, ОСДҮЭ зэрэг холбогдох талууд Монгол болон гадаадын кинонд насны ангилал тогтоох, бүх төрлийн сувгаар түгээхдээ баримтална.

Эрх зүйн үндэслэл

Кино урлагийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээх кинонд насны ангилал тогтоохоор, мөн хуулийн 21.3-т уг шалгуур, журмыг Кино урлагийн зөвлөл Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран батлахаар заасан байдаг.

Насны ангилал (Кино урлагийг дэмжих тухай хуулийн 21.1-д зааснаар)

БҮХ НАС	13+	18+
Бүх насныханд зөвшөөрөх	13 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх	18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх

Журмын зорилго, ач холбогдол

Журам нь кинонд насны ангилал тогтоох нэгдсэн шалгуур, аргачлалыг тодорхойлж, хүүхэд, өсвөр үеийнхнийг нас, сэтгэл зүйн хөгжлийн онцлогт нь тохироогүй агуулгаас хамгаалах, эцэг эх, асран хамгаалагч болон үзэгчдэд киноны агуулгын талаар ойлгомжтой мэдээлэлд үндэслэн сонголт хийх боломж бүрдүүлэх, мөн кино бүтээгч, түгээгчдийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой.

Насны ангилал тогтоох 6 шалгуур

Киноны эрх эзэмшигч агуулгыг үнэлэхдээ дараах зургаан үндсэн шалгуур үзүүлэлтийг цогцоор нь харгалзан насны ангиллыг тогтооно.

1	Гэмт хэрэг, хууль бус үйлдэл бүхий агуулга	2	Хүчирхийлэл болон хүчирхийллийн шинжтэй дүрслэл	3	Бэлгийн агуулга ба садар самуун илэрхийлэл
4	Мансууруулах бодис, архи, тамхи хэрэглээ, сурталчилгаа	5	Хараалын үг, зохисгүй хэллэг	6	Айдас төрүүлэх, сэтгэл зүйд хүчтэй нөлөөлөх дүрслэл

Жич: Киноны агуулгыг шалгуур үзүүлэлт бүрээр үнэлж, өгүүлэмж, дүрслэл, дуу авианы хамгийн хүнд (өндөр) үзүүлэлтэд үндэслэн насны ангиллыг тогтооно. Гадаад киног Монгол Улсад түгээхдээ журмын шалгуурт нийцүүлэн агуулгыг нягталж, нийцээгүй тохиолдолд насны ангиллыг дахин тогтооно.

Тухайн киноны эрх эзэмшигч болон кино зуучлагч нь киноны нэр, үргэлжлэх хугацаа, төрөл, энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, тогтоосон насны ангиллын талаарх мэдээллийг Кино урлагийн зөвлөлд төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан цахим хэлбэрээр хүргүүлснээр кино түгээх боломжтой болно.

Журмын төслийг боловсруулсан явц

Журмын төслийг Кино урлагийн зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороо, Жендэрийн үндэсний хороо, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газар зэрэг төрийн болон салбарын байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг 2025 оны 3 дугаар сард байгуулагдан боловсруулсан.

Төслийг 2025 оны 11 дүгээр сарын 26-наас 12 дугаар сарын 26 хүртэл олон нийтэд нээлттэй байршуулж санал авсан бөгөөд телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч 159 байгууллага, 150 гаруй уран бүтээлчид танилцуулж, нийт 25 гаруй санал ирүүлснийг судалж тусгасан.

Журмын хяналт

Кино урлагийн зөвлөл журмын ерөнхий хэрэгжилтэд, Харилцаа холбооны зохицуулах хороо өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээ болон цагийн хязгаарлалт мөрдөхтэй холбоотой шаардлагын хэрэгжилтэд өөрийн бүрэн эрхийн хүрээнд тус тус хяналт тавина.

Журамтай бүрэн эхээр танилцах: <https://11nq.com/jkvctzi>